

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2018/5



2018 ОН

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	2-3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6-8
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	8-9
 ЭРҮҮЛ МЭНД	9-11
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	11
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	11-12
 ГЭМТ ХЭРЭГ	12-13
 ТӨСӨВ	14
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	14-15
 МАЛ АЖ АХУЙ	15-16
 АЖ ҮЙЛДВЭР	16-17
 ХАРИЛЦАА ХОЛБОО	18
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	18-19

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	34 547	35 813	36 425	36 911	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	354	351	322	304	351
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	929	846	736	233	207
Үүнээс: эмэгтэй	тоо	949	425	396	126	110
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	270	406	344	227	209
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	148	194	214	155	226
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	5 098.6	6 861.8	7 790.7	7 996.5	8 321.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	4 498.4	6 427.1	7 721.9	7 181.2	7 429.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт

	Хэмжих Нэгж	2017 оны V сард				2018 оны V сард					
		Хотын Дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын Дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	296	Баянгол	7 325	Налайх	53	304	Баянгол	7569	Налайх	54
			Чингэлтэй	1 783	Багануур	47		Чингэлтэй	1794	Багануур	49
			Сүхбаатар	659	Багахангай	30		Сүхбаатар	667	Багахангай	29
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	95	Багахангай	528	Сонгинохайрхан	81	92	Багахангай	554	Сонгинохайрхан	68
			Багануур	358	Баянгол	71		Багануур	252	Баянгол	68
			Сүхбаатар	144	Баянзүрх	56		Сүхбаатар	127	Хан-Уул	65
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Багахангай	29	Сүхбаатар	10	9	Хан-Уул	12	Багануур	7
			Багануур	20	Чингэлтэй	9		Чингэлтэй	11	Налайх	3
			Налайх	19	Баянгол	7		Сонгинохайрхан	10	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	99	Баянзүрх	118	Сонгинохайрхан	71	96	Баянзүрх	134	Сонгинохайрхан	75
			Сүхбаатар	95	Налайх	63		Багануур	94	Налайх	57
			Чингэлтэй	87	Багахангай	24		Сүхбаатар	91	Багахангай	27
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	92	Чингэлтэй	103	Сонгинохайрхан	9	78	Сүхбаатар	92	Сонгинохайрхан	18
			Сүхбаатар	60	Налайх	7		Чингэлтэй	72	Налайх	9
			Хан-Уул	37	Багахангай	5		Хан-Уул	50	Багахангай	5
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	76	Сүхбаатар	127	Багахангай	55	139	Сүхбаатар	228	Сонгинохайрхан	89
			Чингэлтэй	97	Сонгинохайрхан	50		Баянзүрх	178	Багахангай	65
			Баянгол	81	Багануур	43		Баянгол	164	Багануур	61

Тайлбар: * - промилль

** - продицимль

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2018 оны V сарын танилцуулга



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 207 иргэн байгаагийн 53.1 хувь нь эмэгтэйчүүд байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хүнээр (11.1%) буурсан байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 11.6 хувь нь 15-24 насны залуучууд, 34.8 хувь нь 25-34 насныхан, 34.8 хувь нь 35-44 насныхан, 15.0 хувь нь 45-54 насны, 2.9 хувь нь 55-59 насны, 0.9 хувь нь 60 ба түүнээс дээш насны ахмадууд, түүнээс 2.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2 (66.6%) буурсан байна.

Хүснэгт 5. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2015		2016		2017		2018	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	1 016	523	736	396	233	126	207	110
Насны бүлгээр:								
15-24	158	80	103	52	52	27	24	8
25-34	350	199	238	128	85	40	72	39
35-44	260	128	198	113	55	32	72	42
45-54	182	91	140	82	37	24	31	19
55-59	48	15	43	16	4	3	6	1
60 +	18	10	14	5	-	-	2	1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	53	23	91	36	3	1	5	1

Хүснэгт 6. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2015 I-V	2016 I-V	2017 I-V	2018 I-V	2015 I-V	2016 I-V	2017 I-V	2018 I-V
Ажилгүйчүүд, бүгд	1 016	736	233	207	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	1	-	1	-	0.1	-	0.4	-
Дипломын болон бакалавр	130	100	31	46	12.8	13.6	13.3	22.2
Тусгай мэргэжлийн дунд	71	51	14	4	7.0	7.0	6.0	2.0
Техникийн болон мэргэжлийн	115	72	20	26	11.3	9.8	8.6	12.5
Бүрэн дунд	513	428	132	110	50.5	58.1	56.7	53.1
Суурь	131	48	22	17	12.9	6.5	9.4	8.2
Бага боловсрол	38	25	8	4	3.7	3.4	3.4	2.0
Боловсролгүй	17	12	5	-	1.7	1.6	2.2	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2018 оны эхний V сард 351 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 103 хүнийг бүртгэлээс хасаж, 98 гэрлэлт, 26 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 хүүхдээр (15.6%), нас баралт өмнөх оны мөн үеэс 13 (14.4%) тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 51.6 хувь нь хүү, 48.4 хувь нь охин байна. Нас баралтад 68.9 хувь нь эрэгтэй, 31.1 хувь нь эмэгтэй хүн байна.

Хүснэгт 7. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Төрсөн хүүхэд, бүгд		351	322	304	351
Үүнээс:	Эрэгтэй	184	160	171	181
	Эмэгтэй	167	162	133	170
Нас баралт, бүгд		99	117	90	103
Үүнээс:	Эрэгтэй	64	75	56	71
	Эмэгтэй	35	42	34	32

Зураг 7. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 8. Бүртгүүлсэн гэр бүл, насны бүлгээр, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2016			2017			2018		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	152	76	76	192	96	96	196	98	98
18-19	1	-	1	-	-	-	-	-	-
20-24	44	21	23	30	13	17	41	14	27
25-29	57	29	28	90	42	48	75	39	36
30-34	27	12	15	37	22	15	42	23	19
35-39	14	9	5	16	8	8	11	8	3
40-44	5	2	3	9	5	4	7	4	3
45-49	2	2	-	7	4	3	7	4	3
50+	2	1	1	3	2	1	13	6	7

Бүртгүүлсэн 98 хос нь тайлант онд гэр бүл болон бүртгэлээ хийлгэсэн бөгөөд бүртгүүлсэн хосуудын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар өссөн байна. Эдгээр 98 гэр бүлийг насны бүлгээр нь ангилбал 21.0% нь 20-24 насны, 38.2% нь 25-29 насны, 21.4% нь 30-34 насны залуучууд, 5.6% нь 35-39 насны, 3.6% нь 40-44 насны, 10.2% нь 45-аас дээш насныхан байна.

Хүснэгт 9. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Гэр бүл цуцлалт, бүгд		23	26	27	26
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	-	2	-
	1-3	2	-	4	-
	4-6	2	-	2	4
	7-9	10	9	4	5
	10-14	2	7	10	9
	15-19	3	2	3	-
	20 ба түүнээс дээш	4	8	2	8

2018 оны эхний 5 сард нийт 26 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 14.3% нь 4-6 жил, 23.8% нь 7-9 жил, 28.6% нь 10-14 жил, 33.3% нь 20-оос дээш жил ханилсан хосууд байжээ.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар өссөн байна. Дүүрэгт 2018 оны эхний 5 сард үрчлэгдсэн 1 хүүхэд байна.

Хүснэгт 10. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд		9	4	10	1
Үүнээс: насны бүлгээр		4	2	8	-
3 хүртэл		1	1	1	-
3-6		1	1	-	1
7-9		3	-	1	-
10 ба түүнээс дээш		9	4	10	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэл, оюуны өмчийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний V сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3781.6 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 1513.2 сая төгрөг (40.0%) нь аж ахуйн нэгж, байгууллага, 1948.8 сая төгрөг(51.6%) нь төсөвт байгууллага, 76.6 сая төгрөг (2.0%) нь эрүүл мэндийн даатгал, 38.4 сая төгрөг (1.0%) нь үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах, 204.6 сая төгрөг (5.4%) нь нөхөн шимтгэл, сайн дурын даатгуулагчдын шимтгэл байгаа юм.

Нийгмийн даатгалын сангаас эхний V сард 26314 даатгуулагч иргэнд 9501.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Хүснэгт. 16 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт


Үзүүлэлт	2017 I-V		2018 I-V	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)
Нийт орлого	-	3 406.1	-	3 781.6
Нийт зардал	62 443	8 614.9	26 314	9 501.3
Тэтгэврийн даатгалын сан	22 906	6 075.4	23 526	7 910.4
Өндөр насны тэтгэвэр	15 610	4 154.5	16 134	5 448.6
Тахир дутуугийн тэтгэвэр	3 861	746.4	3 769	935.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1 468	340.8	1 522	369.5
Цэргийн тэтгэвэр	1 967	833.6	2 101	1 156.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	2 584	1 124.4	1 995	1 135.5
Тахир дутуугийн тэтгэвэр	2 299	1 057.8	1 760	1 065.4
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	151	52.9	116	54.0
Сувиллын зардал	129	11.8	96	6.9
ҮОМШӨ ХЧТА ¹	5	1.9	23	9.2
Тэтгэмжийн даатгалын сан	534	260.2	687	331.1
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	291	28.8	389	36.6
Жирэмсний амралт	172	160.4	222	218.5
Оршуулга	71	71.0	76	76.0
Ажилгүйдлийн даатгалын сан	85	141.9	106	124.2
Ажилгүйдлийн тэтгэмж	85	141.9	106	124.2
Эрүүл мэндийн даатгалын сан	36 334	1 012.9	-	- ²
Эмчилгээ үйлчилгээний зардал	29 959	849.2	-	-
Эмийн үнийн хөнгөлөлт	6 375	163.7	-	-

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Зураг 5. Даатгалын сангийн зарлага

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

² Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эрүүл мэндийн даатгалын газар нь Эрүүл мэндийн яамны харьяа бие даасан агентлаг болсонтой холбоотойгоор энэ онд эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага Эрүүл мэндийн даатгалын газрын сангаас гарах болсон.



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо оны эхний V сард 23526, олгосон тэтгэврийн хэмжээ 7910.4 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 68.9 хувийг өндөр насны 11.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.7 хувийг тэжээгчээ алдсан, 14.6 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний V сард давхардсан тоогоор нийт 6498 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн зардлын хэмжээ өссөн дүнгээр 2467.5 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 17. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2016		2017		2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
	V	I-V	V	I-V	V	I-V
Халамжийн орлого, бүгд	-	1 512.7	-	1 664.0	-	2 477.1
Зарцуулалт, бүгд	5 512	1 475.5	5 007	1 489.0	-	2 467.4
Халамжийн тэтгэвэр	945	515.3	792	500.9	-	546.8
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	630	205.4	-	162.2	-	191.6
Ахмад настны хөнгөлөлт	151	59.3	377	88.1	172	107.9
Халамжийн үйлчилгээ	146	30.2	-	98.7	-	141.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	96	29.1	138	32.7	170	42.8

Хүснэгт 17-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	2016		2017		2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
	V	I-V	V	I-V	V	I-V
Эхчүүдийн мөнгөн тэтгэмж	991	185.4	1 086	150.4	413	62.6
Алдарт эхийн одонгийн тусламж	2 534	333.4	2 603	340.7	2 423	345.2
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	19	9.3	11	9.4	13	11.6
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	-	98.9	-	100.7	-	331.4
Амьжиргааг дэмжих зөвлөл	-	2.1	-	2.8	-	-
Насны хишгийн зардал	-	-	-	-	1 634	128.6
Цалинтай ээж хөтөлбөр	-	-	-	-	1 673	428.6
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	-	-	-	-	-	101.8
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	-	-	-	-	-	26.0
Судалгааны зардал	-	5.5	-	1.2	-	-
Бусад зардал	-	1.5	-	0.8	-	0.8

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ЭРҮҮЛ МЭНД

2018 оны эхний 5 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 44 (14.1%) , нас баралт 13 (13.2%) тус тус өссөн байна.

Хүснэгт 11.Төрөлт жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Амаржсан эхийн тоо, бүгд	408	334	313	357
Амьд төрсөн хүүхэд	407	334	316	362
Амьгүй төрсөн	4	3	3	4
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	97	101	98	111
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	6	11	6	1
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	8	18	5	7
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	69	67	77	82
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ³	20	16	16	22

³ Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

2018 оны эхний V сард бүртгэгдсэн нийт нас баралтын 76.8 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 17.0 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 6.2 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 13. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Нийт халдварт өвчин	429	580	227	209
Халдварт өвчин:	108	344	85	90
Хепатит В вирус	-	5	-	1
Хепатит С вирус	-	-	1	-
Халдварт шар	2	-	-	-
Менинжет	-	-	-	1
Салхин цэцэг	42	24	10	44
паротит	-	-	-	3
Гахай хавдар	2	-	-	-
бруцеллез	-	1	-	-
Ёлом	2	-	3	1
паротит	-	-	-	-
дизентери	4	-	5	6
Гар, хөл, амны өвчин	5	24	59	13
Хоолны хордлого	-	6	-	-
Сальмонеллэз	-	2	-	1
Энтеровируст халдвар	-	-	-	14
Улаан бурхан	49	280	-	-
Улаан эсэргэнэ	-	2	6	3
Эритема	-	-	-	2
Нярайн бактер үжил	1	-	-	-
Хумхаа	-	-	-	-
Экзантема сабитум	-	-	-	1
Хачигт риккетиз	1	-	-	-
хачигт энцефалит	-	-	1	-
Сүрьеэ	23	34	19	21
Арьс өнгөний өвчин	298	202	123	98
Тэмбүү	75	55	27	35
Үүнээс: төрөлхийн	1	-	-	-
Заг хүйтэн	20	27	23	20
Бэлгийн замын мөөгөнцөр	144	49	44	18
Мөөгөнцөр	22	-	6	-
Трихомониаз	37	71	23	25


Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд халдварт өвчнөөр 90 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 (5.9%), сүрьеэгээр 21 хүн өвчилсөн нь 2 (10.5%) тохиолдлоор өсөж, арьс өнгөний өвчлөл 98 гарсан нь 25 (20.3%) хүнээр буурсан байна. Нийт халдварт өвчний гаралт 209 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 (8.0%) буурсан.

Хүснэгт 15. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Урьдчилан сэргийлэх тарилга	2 500	2 599	2 645	2 387
Амбулаторын үзлэг	82 543	84 412	79 853	90 121
Ор хоног	19 558	21 668	20 755	24 336
Эмчийн тоо	72	69	68	75
Сувилагчийн тоо	104	104	95	98
Орны тоо	165	165	177	227

Зураг 6. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 10268 (12.8%), ор хоног 3 581 (17.2%) өссөн байна. Урьдчилан сэргийлэх тарилга 258 (9.8%) буурсан байна.



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2018 оны эхний V сард нийтдээ 5 төрлийн 72 ажил, үйлчилгээг явуулж, 7341.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 18. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ⁴ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	72	20	24	15	5	8	1 051	335

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

танхим

2018 оны эхний V сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 86.3 сая төгрөг болж, орлогын 22.8 хувийг орон сууц, 24.7 хувийг гэр хороолол, 52.5 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 28.8 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 21. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2016	2017	2018	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	85.2	137.5	103.1	22.9	26.0	54.2
Хог тээвэрлэлт, мянган тонн	19.8	22.2	35.3	6.5	21.7	7.2

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 22. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Шахсан ус	мянган м ³	430.8	536.6	430.8	395.4
Борлуулсан ус	мянган м ³	232.7	292.1	232.7	164.8
Үүнээс: Хүн амд	мянган м ³	115.4	107.8	115.3	108.7
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	67.5	116.2	67.5	56.1
Татан зайлуулсан бохир	мянган м ³	189.1	134.2	189.0	161.2
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	199.7	326.3	199.7	196.6
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	125.3	82.9	125.3	159.7
Халаалтын орлого	сая төгрөг	67.5	78.1	67.5	82.6

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2018 оны эхний V сард дүүргийн хэмжээнд 164.8 мянган м³ ус борлуулснаас, 108.7 мянган м³ (66.0%) усыг хүн амд, 56.1 мян.м³ (34.0%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ГЭМТ ХЭРЭГ



Дүүрэгт 2018 оны эхний V сард 226 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 гэмт хэргээр (45.8%) өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 26.5 хувьтай байна.

Дээрх 171 гэмт хэрэгт 38 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл, 16-17 насны 4, 18-24 насны 10, 25-29 насны 7, 30-34 насны 7, 35-39 насны 6, 40-44 насны 2, 45-49 насны 2 хүн байна.

Хүснэгт 23. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	194	214	155	226
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо	16	64	16	170
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь	68.6	71.7	70.9	26.5

Хүснэгт 24. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	
Хүн амины	Санаатай	1	2	2	2
	Учрал	4	10	7	8
Хүчин	-	2	2	1	
Дээрэм	-	-	1	5	
Танхай	4	3	19	-	
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	-	-	3	
Хулгай	Иргэдийн өмчийн	35	53	32	83
	Малын	9	1	5	6
	Халаасны хулгай	-	-	-	1
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	1	2	2	-
	Авто машины	-	-	-	1
Хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг	-	-	-	3	
Булаалт	1	-	-	-	
Залилан	7	9	8	6	
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан	82	84	54	68	
Авто тээвэр	13	8	4	14	
Бусад	37	40	19	25	
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд	188	209	147	66	
Үүнээс:					
Ажилгүй	127	148	108	37	
Албан хаагч	12	12	5	8	
Сурагч	3	5	4	-	
Оюутан	6	1	2	4	
Малчин	5	1	2	-	
Тэнэмэл иргэд	2	-	-	-	
Төрийн бус байгууллагын ажилтан	-	-	1	2	
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	33	42	25	15	
Эрүүлжүүлэгдсэн хүн	1 638	1 385	1 294	1 289	

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 68 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 326.2 сая төгрөгийн хохирол учруулсны 46.2 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2018 оны эхний 5 сард 5997 зөрчил илрүүлж, 5544 хүнийг 157.8 сая төгрөгөөр торгож, 1289 хүнийг эрүүлжүүлж, 9 хүнийг архины албадан эмчилгээнд явуулж, 168 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 19 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.


2017 оны эхний 5 сард гэмт хэргийн гаралт 2-р хороонд 49 гарч хамгийн өндөр байхад 4-р хорооны нутаг дэвсгэрт 21 буюу гэмт хэргийн гаралт хамгийн бага байна.



ТӨСӨВ

2018 оны эхний V сард дүүргийн төсөвт 647.6 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 43.8 сая төгрөгөөр (7.26%) давж биелэв.

Татварын орлогын 47.0 хувийг хүн амын орлогын албан татвар, 18.3 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 0.5 хувийг бууны татвар, 1.2 хувийг ус, рашаан ашигласны төлбөр, 2.5 хувийг түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 8.6 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 21.9 хувийг хүү торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 8000 төгрөгөөр (47.0%), адууны шир 4000 төгрөгөөр (20.0%), үхрийн шир 1500 төгрөгөөр (6.0%), ямааны ноолуур 40000 төгрөгөөр (80.0%), ямааны арьс 2 дахин тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн эхний V сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
		төгрөг			
Тэмээний шир	ширхэг	15 000	20 000	17 000	25 000
Адууны шир	ширхэг	35 000	18 000	20 000	24 000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	50 000	22 500	25 000	26 500
Хонины арьс	ширхэг	2 000	500	4 500	4 500
Ямааны арьс (ноолууртай)	ширхэг	1 500	500	500	1 000
Ямааны ноолуур	кг	48 000	45 000	50 000	90 000

Хүснэгт 4. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2017.V.31					2018.V.30				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1 820	-	1 630	1 720	-	-	1 480	1 680	2 010	-
Петровис	1 820	1 480	1 630	1 720	-	2 050	1 580	1 730	2 010	-
Магнай трейд	1 820	1 480	1 630	1 720	-	2 050	1 480	1 730	2 010	-
Сод монгол	1 820	-	1 630	1 720	-	-	-	1 720	2 010	-
Шунхлай	-	-	1 630	1 720	-	2 050	-	1 730	2 010	-
Юнигаз	-	-	-	-	1 050	-	-	-	-	1 200
Дундаж үнэ	1 820	1 480	1 630	1 720	1 050	2 050	1 513	1 718	2 010	1 200

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 2. Нэг литр шатахууны үнэ



МАЛ АЖ АХУЙ


2018 оны эхний V сард 9807 хээлтэгч малаас 9845 төл гарснаас 12 төл мал хорогдож, 9833 төл бойжиж, төл бойжилт 99.8 хувьтай байна. Бойжсон нийт төлийн 3.1 хувийг унага, 10.8 хувийг тугал, 52.7 хувийг хурга, 33.4 хувийг ишиг эзэлж байна. Дүүргийн хэмжээнд мал төллөлт 41.3 хувьтай байна.

Хүснэгт. 20 Мал төллөлт, том малын хорогдол малын төрлөөр


Үзүүлэлт	2018 I-V					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Төллөсөн хээлтэгч	9 807	-	315	1 063	5 159	3 270
Гарсан төл	9 845	-	315	1 064	5 183	3 283
Хорогдсон төл	12	-	7	5	-	-
Бойжсон төл	9 833	-	308	1 059	5 183	3 283
Бойжилтын хувь	99.8	-	97.8	99.6	100.4	100.4
Хорогдсон том мал	870	-	153	290	266	161
Хорогдсон хээлтэгч	120	-	15	60	31	14

Эх үүсвэр: Хороодын сар бүрийн мал төллөлт, хорогдлын мэдээний нэгдсэн дүн

Зураг 3. Том малын зүй бусын хорогдол малын төрлөөр



Зураг 4. Том малын зүй бусын хорогдол хороодоор



2018 оны эхний 5 сард зүй бус хорогдлоор 33.3% буюу үхэр хамгийн их хорогдож, хамгийн бага буюу 17.6%-иар ямаа хорогдсон байна. Том малын зүй бус хорогдол 3-р хороонд хамгийн их гарч, 320 (37.0%) толгой мал хорогдсон бол 7-р хороонд 22 (2.0%) буюу хамгийн бага хорогдол бүртгэгдсэн байна.

АЖ ҮЙЛДВЭР



2018 оны эхний V сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 18.5%, усан хангамж 61.0 хувиар өсөж, дулаан хангамж 6.8 хувиар буурсан байна. Уул уурхайн олборлолтын салбарын хувьд нүүрс олборлолт 72.5 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 26.3%, дулаан хангамж 26.1%, усан хангамж 25.3%, цементийн борлуулалт 77.3%, оёдлын үйлдвэрлэлт 98.7 % тус тус өссөн байна. Харин нүүрс 73.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 19. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2016	2017	2018	2016	2017	2018
<i>Эрчим хүчний үйлдвэр:</i>							
Цахилгаан	сая.квт.цаг	40.7	45.4	53.7	6 338.8	6 492.4	8 268.1
Дулаан	мянган гкал	64.2	62.2	62.3	1 530.1	1 641.0	1 978.6
Усан хангамж	мянган м ³	541.8	530.7	842.6	184.1	180.4	223.2
<i>Олборлох үйлдвэр:</i>							
Шохой	тонн	3.5	6.3	5.7	35.3	70.2	52.0
Нүүрс	мянган тонн	-	0.8	0.25	-	54.0	14.6
Хайрга	мянган м ³	-	2.4	-	-	20.1	-
Элс	мянган м ³	5.4	4.8	7.7	35.9	34.1	58.2
<i>Боловсруулах үйлдвэр:</i>							
Тоосго	мянган ширхэг	425.6	2 030.9	1 340.0	74.1	233.0	201.8
Цемент	мянган тонн	7.9	5.3	8.5	1 098.4	760.9	1 146.9
Оёдол	мянган ширхэг	-	4.2	13.6	-	59.3	120.3
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	-	-	2.7	-	-	28.9
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	-	-	26.5	-	-	119.2
Замаска	тонн	-	-	74.2	-	-	19.4
Барилгын шавардлагын хар замаска	тонн	-	-	81.1	-	-	21.3
Плитаны цавуу	тонн	-	-	36.7	-	-	12.1
Хэвлэлийн хор	мянган ширхэг	-	-	12.5	-	-	200.3
<i>Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:</i>							
Талх	мянган ширхэг	-	-	18.8	-	-	36.3
Нарийн боов, жигнэмэг	тонн	-	-	11.5	-	-	27.1
Хэрчсэн гурил	тонн	-	-	0.41	-	-	371.7

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 95.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 46.6 сая төгрөг (49.0%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 34-өөр (6.2%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 331 (56.7%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 188 (32.2%) нь төсвийн байгууллагад, 65 (11.1%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 26. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Нийт орлого	сая төгрөг	89.1	91.5	91.3	95.2
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	43.6	44.8	44.7	46.6
Телефон цэг	тоо	631	568	550	584
Үүнээс: айл өрх	тоо	359	331	306	331
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	9 864	9 780	7 968	2 136
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	244	237	332	320
Таксофон	тоо	1	1	1	1

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	6	-	280	122	188	65	7	7

Хүснэгт 27. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн эхний V сард

Эх үүсвэр: Өмч, газрын харилцааны алба

2018 оны эхний V сард дүүргийн Засаг даргын 39 тоот захирамжаар нийт 675 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2018 оны эхний V сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, нийт 950 айл өрх, 254 аж ахуйн нэгж, байгууллагад 875 зөрчил илрүүлэн, 140 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 55, мэдэгдэл 112, зөрчлийн тэмдэглэл 37, дүгнэлт 12, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 54 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 41 дуудлагаар ажиллаж, 222.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 24. Гал түймрийн дуудлагын тоо жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Бүгд		42	46	39	41
<i>Өмчийн хэлбэрээр:</i>					
Төрийн өмч	тоо	13	1	2	4
Хувийн өмч	тоо	27	34	32	37
Аж ахуйн нэгж	тоо	2	9	5	-
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	2	-	-
<i>Гал түймэрт өртөж шатсан:</i>					
Нас барсан	хүүхэд том хүн	- -	- -	- 1	- 1
Түлэгдэж бэртсэн	хүүхэд том хүн	- -	- -	- 1	- -
Өвөл зуны сууц	тоо	9	7	5	10
Гэр	тоо	5	7	5	7
Хог, хогийн суваг	тоо	16	9	9	9
Машин техник	тоо	4	5	-	3
Барилга байгууламж	тоо	-	2	6	2
Малын хашаа саравч	тоо	8	6	2	-
<i>Шалтгаан:</i>					
Цахилгааны	тоо	7	10	2	2
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	26	18	3	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	-	-	9
Пийшин зүүхны цоонолт	тоо	5	9	1	-
Газрын тосны бүтээгдэхүүн буруу ашигласан	тоо	-	-	-	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	4	2	1
Архидан согтуурсанаас	тоо	-	-	2	1
Бусад	тоо	-	4	5	41
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	3	1	24	28
<i>Аварсан эд хөрөнгө:</i>					
Хүн	тоо	-	-	-	1
Өвөл зуны сууц	тоо	5	5	1	4
Гэр	тоо	4	-	-	3
Барилга байгууламж	тоо	2	4	-	2
Машин техник	тоо	4	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	3	4	-	2

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2018 оны эхний V сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 146 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 106 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 9-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 93.8 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 106 (72.6%) нь бичгээр, 40 (27.4%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn

www.nad.ub.gov.mn

Утас: 7023-3672